



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/150.

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг эхээс хандивласан 1,800,000.0 (нэг сая найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль (Э.Гунгаажав)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль (Э.Гунгаажав)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
 даргын 2024 оны 12 дугаар сарын 21-ны
 өдрийн 130 дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэр- лэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Спорт залны онооны самбар		220-240	2021	шинэ	ш	1	1,800,000.00	1,800,000.00	Эцэг эхчүүд	Хандив
Нийт хөрөнгийн дүн								1,800,000.00	1,800,000.00		